

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ ХАРААТ БУС АУДИТЫН
КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ,
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ**

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Журмын зорилго, хамрах хүрээ

- 1.1 Төрийн аудитын байгууллага (цаашид “захиалагч” гэх) Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргийг гүйцэтгэх хараат бус аудитын компани (цаашид “гүйцэтгэгч” гэх)-ийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээг дүгнэж хариуцлага тооцох, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2 Энэхүү журам нь “Аудитын үйлчилгээний тендерийн баримт бичиг”-ийн загвар нэгдүгээр хавсралт, “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний загвар хоёрдугаар хавсралтаас тус тус бүрдэнэ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХ

Хоёр. Сонгон шалгаруулах үе шат

- 2.1 Гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” (цаашид “ТБОНӨХБАҮХАТХ” гэх)-ийн дагуу сонгон шалгаруулна.
- 2.2 Сонгон шалгаруулалтыг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан явуулна.
- 2.3 Үндэсний Аудитын Газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь энэ журмын дагуу бие даан тус тусын харъяалах байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна.
- 2.4 Гүйцэтгэгчээр аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй хараат бус аудитын компанийг сонгоно.
- 2.5 Гүйцэтгэгчийг сонгохдоо “Чанарын үнэлгээний арга”-ыг хэрэглэнэ.
- 2.6 Сонгон шалгаруулалтад хамтран ажиллах “Түншлэлийн гэрээ”-ний үндсэн дээр нэгээс дээш хэд хэдэн этгээд хамтран оролцож болно.
- 2.7 Сонгон шалгаруулах үйл явц нь дараах үе шатаас бүрдэнэ.
- 2.7.1 *Аудит хийгдэх байгууллагуудыг бүлэглэж багц үүсгэх*
- 2.7.1.1 Үндэсний Аудитын Газар болон аймаг, нийслэлийн аудитын газар дараах үүргийг гүйцэтгэнэ.
- 2.7.1.1.1 Тухайн жилд хараат бус аудитын компаниар санхүүгийн тайланд аудит хийлгэх нийт төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон

нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийн жагсаалт, тэдгээрийн талаарх ерөнхий мэдээллийг гаргах

2.7.1.1.2 Аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хараат бус аудитын компаниудын жагсаалтыг гаргах

2.7.1.1.3 Хараат бус аудитын компаниудын төрийн аудитын байгууллагатай гэрээгээр гүйцэтгэсэн өмнөх хугацааны санхүүгийн тайлангийн аудитын ажлын чанарын судалгаа гаргах

2.7.1.1.4 Хараат бус аудитын компаниар санхүүгийн тайланд аудит хийлгэх төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл хөтөлбөрийг бүлэглэж багц үүсгэх, Монгол Улсын Ерөнхий аудитораар батлуулах

2.7.2 Үнэлгээний хороо байгуулах

2.7.2.1 Төрийн аудитын байгууллага нь Үнэлгээний хороог дарга, нарийн бичиг, гишүүд гэсэн бүрэлдэхүүнтэй, сондгой тооны гишүүдтэй байгуулна.

2.7.2.2 Үндэсний Аудитын Газрын хувьд Үнэлгээний хороог Тамгын Газар, Стратегийн Удирдлагын Газар болон Санхүүгийн Аудитын Газраас гишүүдийг бүрдүүлэхээс гадна тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөллийг оролцуулна.

2.7.2.3 Аймаг, нийслэлийн аудитын газрын хувьд санхүүгийн аудитын албанаас гишүүдийг бүрдүүлэхээс гадна тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

2.7.2.4 Үнэлгээний хорооны гишүүн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.3, 47.6-д заасан шаардлагын хангаж буйгаа “Үнэлгээний хороонд гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”, “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” маягтын дагуу бичгээр мэдэгдэнэ.

2.7.2.5 Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичиг боловсруулах, ажлын даалгавар бэлтгэх, тендерийн урилгыг зарлан мэдээлэх, тендер хүлээж авах, нээх, тендерийн үнэлгээ хийх, үнэлгээ хийхэд зайлшгүй шаардлагатай мэдээллийг олж авах, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг захиалагчид өгөх, тендерийн хавтаст хэрэг бүрдүүлэх, гэрээ байгуулахад захиалагчид арга зүйн туслалцаа үзүүлэх үүргийг хүлээнэ.

2.7.2.6 Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

2.7.3 Тендерийн баримт бичгийг боловсруулах, захиалагчаар батлуулах

- 2.7.3.1 Үнэлгээний хороо саналын урилгыг багтаасан тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
- 2.7.3.2 Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ажлын даалгаврыг бэлтгэж, төсөвт өртгийг тооцоолно.
- 2.7.3.3 Ажлын даалгаварт тусгах саналыг холбогдох газар, хэлтсээс Үнэлгээний хороонд тендер зарлахын өмнө ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө албан ёсоор ирүүлнэ.
- 2.7.3.4 Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа тендерийн жишиг баримт бичгийн “Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт”, “Гэрээний тусгай нөхцөл”-ийг өөрчлөн найруулах ба ажлын даалгаврыг хараат бус аудитын компаниар гүйцэтгүүлэх санхүүгийн тайлангийн аудитын ажлын зорилго, цар хүрээг харгалзан бэлтгэнэ.
- 2.7.3.5 Тендерийн баримт бичигт багцуудын талаах мэдээллийг оруулахаас гадна тендерт оролцогч нэг буюу хэд хэдэн, эсвэл бүх багцад саналаа ирүүлж болохыг заана.
- 2.7.3.6 Тендерийн баримт бичигт энэ журмын 2.7.3.2-д заасан төсөвт өртгийг үндэслэн дараах байдлаар баталгаа ирүүлэхийг шаардана. Үүнд:
 - 2.7.3.6.1 100.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй тендерт төсөвт өртөгийн 1-2 хувьтай-тай тэнцэх хэмжээний тендерийн баталгаа ирүүлэхийг шаардана.
 - 2.7.3.6.2 100.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ба гэрээ нь 2 жилээс дээш хугацаагаар үргэлжлэх бол гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний гүйцэтгэлийн баталгаа заавал ирүүлэхийг шаардана.
- 2.7.3.7 Гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг гэрээний хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг тендерийн баримт бичигт тусгаж болно.
- 2.7.3.8 Тендерийн баримт бичиг, урилгыг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд монгол хэлээс гадна гадаад хэл дээр бэлтгэж болно.
- 2.7.3.9 Захиалагч Үнэлгээний хорооны боловсруулсан тендерийн баримт бичгийг гэрээний маягтын хамт батална.

2.7.4 Тендерийг зарлан мэдээлэх, хураангуй жагсаалт үүсгэх

- 2.7.4.1 Сонгон шалгаруулалтад оролцогчдын дэлгэрэнгүй жагсаалтад орох саналаа ирүүлэхийг хүссэн урилгыг өдөр тутмын сонин болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгсэл мөн www.audit.mn цахим хуудсанд нийтэлнэ.
- 2.7.4.2 Дэлгэрэнгүй жагсаалтад урилгын хариуд санал ирүүлсэн хараат бус аудитын компанийг оруулах ба санал ирүүлэх хугацааг ажлын 7-оос доошгүй өдрөөр тогтооно.

2.7.4.3 Дэлгэрэнгүй жагсаалтад багтсан этгээдээс дараах шаардлагыг хангасан этгээдийг хураангуй жагсаалтад бүртгэнэ. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглабар хугацаатай нийцсэн эсэх;
- Аудитын компани нь хариуцлагын даатгалтай эсэх;
- Аудитын компанийн захирал нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй эсэх;
- Аудитын компани нь 3-аас доошгүй мэргэшсэн нягтлан бодогчтой эсэх;
- Аудитын компанийн захирал болон мэргэшсэн нягтлан бодогчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаагүй талаар Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ)-ийн тодорхойлолттой эсэх;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн 21.1 дэх заалтыг зөрчөөгүй байх;
- Төрийн аудитын байгууллагын захиалгаар сүүлийн 3 жилийн хугацаанд аудитын ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх, хэрэв ийм ажил гүйцэтгээгүй бол мөн хугацаанд улсын салбарт ижил төстэй ажил хийсэн туршлагатай байх;
- Сангийн Яам болон бусад мэргэжлийн байгууллагаас хийгдсэн чанарын баталгаажуулалтын дүгнэлт.

2.7.5 *Тендерийн баримт бичгийг худалдах, тодруулга, нэмэлт мэдээлэл өгөх*

2.7.5.1 Тендерийн баримт бичгийг түүнийг хэвлэн олшруулах, түгээх буюу тендер шалгаруулалтыг зохион байгуулах өртгөөр үнэлнэ.

2.7.5.2 Тендерт оролцогч Үндэсний Аудитын Газрын дансанд худалдах үнийг тушааж, тендерийн баримт бичгийг худалдаж авна.

2.7.5.3 Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг бичгээр тавьсан бол захиалагчаас хариу тодруулга, нэмэлт мэдээллийг тендерийн баримт бичиг худалдан авсан бүх сонирхогчдод нэгэн зэрэг бичгээр өгнө.

2.7.6 *Тендер хүлээн авах, нээх*

2.7.6.1 Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь саналын урилга илгээснээс хойш хуулийн этгээдийн хувьд 30-аас дээш хоног байх ба үүнийг саналын урилгад заана.

2.7.6.2 Тендерийн баримт бичигт тендер ирүүлэх хугацаа, хаяг, хэлбэр зэргийг тодорхой заасан байх ба тендер ирүүлэх

хугацаанд оролцогч нэмэлт, өөрчлөлт оруулах, татгалзах саналаа ирүүлж болно.

2.7.6.3 Тендерт оролцогч нэгээс дээш хэд хэдэн багцад саналаа ирүүлсэн бол тендерийн саналыг багц тус бүрт хүлээн авна.

2.7.6.4 Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хожимдож ирсэн, эсхүл тендерийн баримт бичигт зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн тендерийг хүлээж авахгүй.

2.7.6.5 Үнэлгээний хороо хүлээн авсан бүх тендерийг тендерийн баримт бичигт заасан газарт нийтийн өмнө тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор нээж, тэмдэглэл үйлдэнэ.

2.7.7 Тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах

2.7.7.1 Тендер нээсний дараа тендер тус бүрийг дараах шаардлагын дагуу хянан үзнэ.

Эрх бүхий эсэх	- Төлбөрийн чадвартай - Татан буугдаагүй - Бизнесийн үйл ажиллагааг нь зогсоогоогүй - Хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн - Сүүлийн 3 жилийн хугацаанд Төрийн аудитын байгууллагатай хийсэн гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй тохиолдол гаргаагүй - Мэргэжлийн үйл ажиллагаандаа алдаа гаргаагүй - Шаардсан мэдээллийг үнэн зөв мэдээлсэн - Сүүлийн 3 жилийн хугацаанд авилгын гэмт хэрэгт холбогдсон тохиолдол гаргаагүй
Санхүүгийн чадавхитай эсэх	Сүүлийн 3 хүртэлх санхүүгийн жилийн баталгаажуулсан санхүүгийн тайлангаарх нийт борлуулалтын орлого
Техникийн чадавхитай эсэх	- Сүүлийн 3 хүртэлх санхүүгийн жилд улсын салбарт хийсэн нийт аудитын ажил - Үйлчилгээ үзүүлэх албан ёсны хаяг бүхий ажлын байр, хангалттай техник хэрэгсэлтэй байх - Нийт үндсэн орон тооны ажилтны тоо хангалттай байх, мэргэшсэн нягтлан бодогчийн зэрэг, аудитын батламжтай ажилтны тоо хангалттай байх - Нэгээс дээш хэд хэдэн багцад тендерийн саналаа ирүүлсэн тендерт оролцогч саналаа ирүүлсэн багцуудад багтсан аудитын ажлуудыг нэг хугацаанд хийж гүйцэтгэх чадвартай эсэх

2.7.7.2 Тендерийн баримт бичигт шаардсан техникийн саналын дараах маягтын дагуу оролцогч тус бүрийг багц тус бүрээр үнэлнэ.

Маягт 3.2	Аудитын ижил төстэй ажлын туршлага
Маягт 3.3	Ажлын даалгаварт өгсөн санал, зөвлөмж
Маягт 3.4	Аудитын ажлыг гүйцэтгэх ажлын хөтөлбөр болон аргачлал

Маягт 3.5	Ажиллах багийн бүрэлдэхүүн, ажлын хуваарилалт
Маягт 3.6	Санал болгож буй багийн гишүүдийн намтар
Маягт 3.7	Аудитын багийн гишүүдийн ажлын хуваарь
Маягт 3.8	Аудитын ажлын хуваарь

2.7.7.3 Техникийн саналд оноо өгөхдөө дараах үзүүлэлтийг харгалзан үзнэ.

Оноо	Үзүүлэлт
30	Тендерт оролцогчийн санал болгож буй аудитын ажлын хөтөлбөр болон аргачлал нь захиалагчийн ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал
40	Захиалагчийн ажлын даалгаварт заасан аудитын ажлыг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага (үүний дотор 10-20 хувь нь өмнөх хугацаанд Төрийн аудитын байгууллагатай гэрээний үндсэн дээр хийсэн аудитын ажлын чанарын хяналтын үнэлгээнд тооцогдоно.)
30	Тендерт оролцогчийн голлох мэргэжилтнүүдийн чадвар болон туршлага
100	Техникийн саналд авбал зохих доод оноо: 70

2.7.7.4 Түншлэлийн техникийн саналыг үнэлэхдээ хамтран ажиллах компаниуд нь тус бүрдээ шаардлага хангасан байхыг харгалзан үзэхээс гадна тэдгээрийн чадвар, туршлагыг нэмж тооцно.

2.7.7.5 Түншлэлийн санхүүгийн чадавхийг үнэлэхдээ төлөөлөгч нь 40 хувь, гишүүд нь 25-аас багагүй хувийг хангасан байхыг шаардана.

2.7.7.6 Үнэлгээний хороо техникийн саналын нийт оноог гарган захиалагчид хүргүүлнэ.

2.7.7.7 Үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн техникийн саналын дүнг тендерт оролцогчдод албан бичгээр мэдэгдэнэ. Энэ албан бичигт санхүүгийн саналын нээлт болох хугацааг зааж өгсөн байна.

2.7.7.8 Техникийн саналын оноог албан бичгээр мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа санхүүгийн саналыг нээнэ.

2.7.7.9 Багц тус бүрийн хувьд техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан тендерт оролцогчийн санхүүгийн саналыг нээж, тухайн оролцогчийн санхүүгийн болон бусад нөхцлийг харилцан тохиролцох хэлэлцээр хийнэ.

Шалгарсан тендерт оролцогчтой санхүүгийн, эсхүл гэрээний бусад нөхцөлөөр харилцан тохиролцоонд хүрээгүй бол Үнэлгээний хороо дараагийн өндөр оноо авсан тендерт оролцогчийн санхүүгийн саналыг нээн, түүнтэй хэлэлцээр хийнэ.

2.7.7.10 Үнэлгээний хороо нь үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хурлын тэмдэглэл хэлбэрээр гаргах ба хорооны гишүүдийн олонх

дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох мэдээллийг агуулсан байна.

2.7.7.11 Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байгаа гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухай тэмдэглэж гарын үсэг зурна.

2.7.8 Гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах

2.7.8.1 Багц бүрийн хувьд шалгарсан тендерт оролцогчтой хийсэн харилцан тохиролцох хэлэлцээр амжилттай болсон тохиолдолд захиалагч уг тендерт оролцогчтой гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

2.7.8.2 Гэрээ байгуулах эрхийг багц тус бүрээр, эсвэл хэд хэдэн багцаар буюу бүх багцаар олгож болно.

2.7.8.3 Захиалагч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна.

2.7.9 Тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлэх, материал танилцуулах

2.7.9.1 Үнэлгээний хороо тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивт шилжүүлнэ.

2.7.9.2 Тендер шалгаруулалтын хавтаст хэргийг ТБОНӨАБАҮХАТ хуульд заасны дагуу бүрдүүлнэ.

2.7.9.3 Бичгээр хүсэлт гаргасан тендерт оролцсон этгээдэд тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэрийг танилцуулж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГҮЙЦЭТГЭГЧТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ, ХАРИУЦЛАГА ТООЦОХ

Гурав. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах хэлбэр, хугацаа

3.1 Захиалагч талаас Үндэсний Аудитын Газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь гүйцэтгэгч болон аудит хийлгэх төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага (цаашид “үйлчлүүлэгч” гэх)-тай “Аудит ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г байгуулж, Монгол Улсын Ерөнхий аудитораар батлуулна.

3.2 “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-нд захиалагч, гүйцэтгэгч, үйлчлүүлэгч гурван тал баталгаажуулж гарын үсэг зурах бөгөөд гэрээний загварыг энэхүү журмын 2 дугаар хавсралтад тусгасан болно.

3.3 Гүйцэтгэгч тал Төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс гүйцэтгэх аудитын ажилд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний загварыг зөвхөн ашиглана.

- 3.4 “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ” нь байгуулагдсанаас хойш нэг жилийн хугацаатай байх ба энэ журмын 5.4-д заасны дагуу аудитын ажлын чанарын хяналтын үнэлгээнд үндэслэн гэрээ сунгагдах эсэхийг шийднэ.
- 3.5 Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын даалгавар нь “Аудитын ажил гүйцэтгэх гэрээ”-ний салшгүй хэсэг болно.
- 3.6 Захиалагч гэрээ байгуулахын өмнө ажлын даалгаварт гүйцэтгэгчээр хийлгэх аудитын ажлын зорилго, цар хүрээ нь зохистой, хангалттай хэмжээнд тусгагдсан эсэхийг сайтар шалгаж, гүйцэтгэгчтэй хэлэлцэж тохиролцсоны үндсэн дээр шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг хийж болно.

Дөрөв. Гэрээнд талуудын хүлээх үүрэг

4.1 Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээнд захиалагч дараах үүрэг хүлээнэ.

- 4.1.1 Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, “Санхүүгийн тайлангийн аудитын гарын авлага” болон холбогдох бусад арга зүйн материалаар гүйцэтгэгчийг хангах
- 4.1.2 Гүйцэтгэгчийн аудиторуудыг Төрийн аудитын байгууллагын санхүүгийн аудитын програм хангамж, арга зүйн сургалтад тухайн жилийн аудит эхлэхийн өмнө хамруулах
- 4.1.3 Захиалагч аудитын ажлын баримт материалыг өөрийн байранд болон гүйцэтгэгч, үйлчлүүлэгчийн ажлын байранд нягтлах, хянах
- 4.1.4 Гүйцэтгэгчийн бэлтгэсэн аудитын тайлан, дүгнэлт, менежментийн захидалд үндэслэн хянасны дагуу гэрчилгээ, акт, албан шаардлагыг зохих журмын дагуу гаргах
- 4.1.5 Гүйцэтгэгчийг статистик мэдээ, судалгаа, шинжилгээ гаргах, нэгтгэх маягт заавраар хангах
- 4.1.6 “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ” байгуулагдсаны дараа Сангийн яамтай зөвшилцсөнөөр дундын данс (эскроу данс)-ыг шаардлага хангасан арилжааны банкинд нээж, аудитын үйлчилгээний төлбөрийг байршуулах
- 4.1.7 Гүйцэтгэгчийн аудитын үйлчилгээний төлбөрийн 30 хувийг “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ” байгуулж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг хүлээн авч, аудитын төлөвлөлтийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж хангалттай гэж үзэж баталснаар, 30 хувийг аудитын гүйцэтгэлийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж хангалттай гэж үзэж баталснаар, 30 хувийг аудитын тайланг хүлээн авч, тайлагналын хяналтыг хэрэгжүүлж хангалттай гэж үзэж баталснаар банкны дундын данснаас гүйцэтгэгчид төлөх
- 4.1.8 ТБОНӨАБАҮХАТ хуульд заасны дагуу аудитын үйлчилгээний төлбөрийн 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын талаар эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд банкны дундын данснаас гүйцэтгэгчид төлөх

- 4.1.9 Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцэх явцад болон дараа нь гүйцэтгэгчийн хийсэн аудиттай холбоотой эрсдэлтэй асуудал гарсан бол түүнийг гүйцэтгэгчид даруй мэдэгдэж, шаардлагатай засварыг хийлгэх, нотолгоо баримтыг шаардаж авах

4.2 Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээнд үйлчлүүлэгч дараах үүрэг хүлээнэ.

- 4.2.1 Төрийн аудитын тухай хуулийн 18.6-д заасны дагуу аудитын үйлчилгээний төлбөрийг жилийн төсөвтөө тусгаж батлуулах
- 4.2.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн стандарт, Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабрын дагуу тогтоосон хугацаанд гүйцэтгэгчид ирүүлэх, аудит хийлгэх
- 4.2.3 Гүйцэтгэгчийн шаардсан аудиттай холбоотой, тайлан, тооцоо, санхүүгийн баримт, мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, холбогдох бусад баримт материалыг саадгүй гаргаж өгөх
- 4.2.4 Гүйцэтгэгчийг үйлчлүүлэгчийн байранд ажиллах нөхцөл бололцоогоор хангах

4.3 Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээнд гүйцэтгэгч дараах үүрэг хүлээнэ.

- 4.3.1 Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль болон Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, “Санхүүгийн тайлангийн аудитын гарын авлага”, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, энэхүү журам, холбогдох бусад дүрэм, журмын дагуу ажиллах
- 4.3.2 Гүйцэтгэгчийн аудиторууд “Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг мөрдөж ажиллаж, УИХ-ын Байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг Төрийн аудитын байгууллагад бичгээр гаргаж өгөх
- 4.3.3 Гүйцэтгэгч аудит хийх явцад олж авсан мэдээллийн нууцыг Төрийн аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу хамгаалах
- 4.3.4 Гүйцэтгэгч аудитын ажил талбарын эхлэхээс өмнө аудитын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, хөтөлбөрийг захиалагчаар хянуулж, батлуулах
- 4.3.5 Аудитын явцад захиалагч байгууллагын хариуцсан ажилтантай байнгын харилцаатай байж, аудитын явц, эрсдэл болон горимын талаар мэдээлж, арга зүйн зөвлөгөө авах, асуудлыг хэлэлцэх
- 4.3.6 Гүйцэтгэгчээс үйлчлүүлэгчтэй хийх уулзалтанд шаардлагатай тохиолдолд захиалагчийн төлөөллийг оролцуулах
- 4.3.7 Захиалагчийн зүгээс аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны явцын хяналтыг хийх үед гүйцэтгэгч аудитын ажлын баримт материалыг бэлэн байлгах
- 4.3.8 Гүйцэтгэгч аудитын ажил гүйцэтгэж дууссанаас хойш аудитын ажлын баримт материалыг өөртөө хадгалах бөгөөд Аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-д заасны дагуу 10 жилийн хугацаанд ажлын

- болон нотлох баримт материалыг хадгалж, шаардлагатай үед үзэх боломжийг захиалагчид олгох
- 4.3.9 Аудитын төлөвлөлт, гүйцэтгэлийн үе шатанд гүйцэтгэгчийн хяналтыг Чанарын Хяналтын Олон Улсын Стандарт 1-ийн дагуу хийж гүйцэтгэх
- 4.3.10 Аудитын тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагын саналд гүйцэтгэгчийн удирдлагын тайлагналын үе шатны хяналтыг чанартай хийж гүйцэтгэх, тайлангийн тоо дүн, агуулгатай холбоотой алдаагүй тайланг захиалагчид хүлээлгэн өгөх
- 4.3.11 Аудитын ажлыг дуусгавар болгосноор дараах баримт, материалуудыг захиалагчид хүлээлгэн өгөх
- Аудитын ажилд гүйцэтгэгчийн удирдлагаас хэрэгжүүлсэн аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны чанарын хяналтын хуудас
 - Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт албан шаардлагын санал, хуулийн байгууллагад шилжүүлэх болон хариуцлага тооцуулах саналтай холбоотой нотлох баримт
 - Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
 - Үйлчлүүлэгчийн ирүүлсэн санхүүгийн тайлангийн эх хувь
 - Үйлчлүүлэгч байгууллагаар баталгаажуулсан аудитаар илэрсэн асуудлыг бүртгэл
 - Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл, ач холбогдлын шинжилгээ-маягт
 - Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хянасан байдал
 - Захиалагчид шаардлагатай судалгаа, мэдээлэл
- 4.3.12 Гүйцэтгэгч аудитын үйлчилгээний төлбөрийн 30 хувийг “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ” байгуулж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг хүлээн авч, аудитын төлөвлөлтийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж хангалттай гэж үзэж баталснаар, 30 хувийг аудитын гүйцэтгэлийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж хангалттай гэж үзэж баталснаар, 30 хувийг аудитын тайланг хүлээн авч, тайлагналын хяналтыг хэрэгжүүлж хангалттай гэж үзэж батлуулсанаар захиалагч руу нэхэмжлэх
- 4.3.13 ТБОНӨАБАҮХАТ хуульд заасны дагуу аудитын үйлчилгээний төлбөрийн 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын талаар эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд захиалагч руу нэхэмжлэх
- 4.3.14 Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцэх явцад болон дараа нь гүйцэтгэгчийн хийсэн аудиттай холбоотой эрсдэлтэй асуудал гарсан бол Төрийн аудитын байгууллагын мэдэгдсэнээр гүйцэтгэгч шаардлагатай засварыг хийх, нотолгоо баримтаар хангах

Тав. Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх

- 5.1 Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтийг захиалагч тал гүйцэтгэгч болон үйлчлүүлэгчтэй хэлэлцэн зөвшилцөж дүгнэнэ.
- 5.2 Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа дүгнэнэ.
- 5.3 Гэрээний үүргийн биелэлтийг үнэлэхдээ Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан ажлын гүйцэтгэл тооцох бодлого, арга зүй, шалгуур үзүүлэлтийг мөрдлөг болгох бөгөөд дараах гол үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ.
- Жилийн эцсийн аудитын тайлан, зөвлөмж, акт албан шаардлагын гэрээнд заасан хугацааны дотор хүлээлгэн өгсөн байх
 - Аудитаар илрүүлсэн зөрчлийн ач холбогдол, үр дүн, илрүүлэлт
 - Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын ажлын чанарын хяналтын үнэлгээ
- 5.4 Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын ажлын чанарын хяналтын үнэлгээгээр 85 хувиас дээш оноо авсан бол гэрээг сунгах үндэслэл болно.

Зургаа. Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх

- 6.1 Дараах тохиолдолд гүйцэтгэгчийг дараагийн сонгон шалгаруулалтад ашиглах Төрийн аудитын байгууллагын хураангуй жагсаалтад багтах эрхийг нэг жилийн хугацаанд хязгаарлана.
- Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын ажлын чанарын хяналтын үнэлгээгээр 85 хувиас доош үнэлгээ авсан
 - Энэ журмын 4.3.11-д заасан баримт материалуудыг захиалагчид хүлээлгэн өгөөгүй
 - Төрийн аудитын байгууллагын хариуцсан ажилтныг шаардлагатай тодруулга, судалгаа, нотлох баримт, мэдээллээр хангаагүй, эсвэл татгалзсан, дутуу эсвэл буруу мэдээллээр хангасан
- 6.2 Дараах тохиолдолд Төрийн аудитын байгууллагын санаачилгаар “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г цуцлах ба уг гүйцэтгэгчийг дараагийн 2 жилийн хугацаанд Төрийн аудитын байгууллагын “сонгон шалгаруулалтад орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д оруулна.
- Үйлчлүүлэгч, захиалагчаас хамаарснаас бусад шалтгааны улмаас аудитын ажлыг огт гүйцэтгээгүй
 - Аудитын ажлыг өөр бусад байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлсэн
- 6.3 Төрийн аудитын байгууллагын санаачилгаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээний төлбөрийн нөхцөлийн дагуу төлөгдсөн төлбөрийг буцаан төлүүлж, уг гүйцэтгэгчийг дараагийн 2 жилийн хугацаанд Төрийн аудитын байгууллагын “сонгон шалгаруулалтад орох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д оруулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АУДИТЫН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ, БАТАЛГААЖУУЛАХ

Долоо. Аудитын ажлын чанарыг хянах, үнэлэх

7.1 Үндэсний Аудитын Газар болон аймаг, нийслэлийн аудитын газар гүйцэтгэгчийн хийсэн аудитын ажлын чанарын хяналтыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/94 дүгээр тушаалаар батлагдсан “Аудитын чанарын хяналтын журам”-ын дагуу хэрэгжүүлнэ.

7.2 Төрийн аудитын байгууллага нь гүйцэтгэгчийн хийсэн аудитын ажлын чанарын хяналтыг дараах 3 үе шатанд хэрэгжүүлнэ.

- (i) Аудитын төлөвлөлтийн үе шатны хяналт
- (ii) Аудитын гүйцэтгэлийн үе шатны хяналт
- (iii) Аудитын тайлагналын үе шатны хяналт

7.3 Аудитын ажлын чанарын хяналтыг гүйцэтгэгчийн багцад багтсан бүх аудитын ажилд хэрэгжүүлнэ.

7.4 Аудитын төлөвлөлтийн үе шатны хяналтыг дараах асуудлуудад чиглүүлнэ.

- Үйлчлүүлэгчийн холбогдох ажилтнуудтай уулзалт зохион байгуулж, хангалттай мэдээлэлд үндэслэн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулсан эсэх
- Төсвийн тухай хуульд заасан цагалбарын дагуу аудитын ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг төлөвлөж батлуулсан эсэх
- Ажлын хамрах хүрээг зөв тодорхойлсон эсэх
- Аудитын урьдчилсан судалгаа хийсэн эсэх
- Эрсдэлийг тооцон үнэлж, хэрэгжүүлэх горимыг зөв тодорхойлсон эсэх
- Аудитын багийн гишүүдийн ажлын хуваарь, зохион байгуулалтыг оновчтой зөв тодорхойлсон эсэх
- Холбогдох техник хэрэгслийг урьдчилан бэлтгэх, шаардлагатай шинжээч, мэргэжилтнүүдийг аудитын баг бүрт оролцуулсан эсэхийг тодорхойлох

7.5 Аудитын гүйцэтгэлийн үе шатны хяналтыг дараах асуудлуудад чиглүүлнэ.

- Аудиторууд аудитыг хийхдээ холбогдох стандартууд, хуулийн заалтуудыг баримталж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу горимыг хэрэгжүүлсэн эсэх
- Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, “Санхүүгийн тайлангийн гарын авлага”-ын дагуу ажлуудыг гүйцэтгэж, батлагдсан маягыг хөтөлсөн эсэх

7.6 Тайлагналын үе шатны чанарын хяналтыг дараах асуудлуудад чиглүүлнэ.

- Аудитын тайлангийн төслийн хэлбэр, бүтцийг хянах
- Аудитын тайлангийн төслийн агуулгыг хянах, зохих загварын дагуу бэлтгэсэн эсэхийг хянах
- Аудитын дүгнэлт, менежментийн захидалд тусгагдсан зөвлөмж нь хангалттай зохистой нотлох баримтаар нотлогдсон эсэх, тайлангийн төслийн хавсралтууд бүрэн, зохих ёсоор бэлтгэгдсэн эсэхийг хянах

- Аудитын тайлангийн төсөлд үйлчлүүлэгчээс ирүүлсэн саналыг хэрхэн харгалзан үзсэн эсэхийг хянах
- Акт, албан шаардлагын төслийг Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөх журам”-ын дагуу эсэхийг хянах

7.7 Аудитын үе шатны чанарын хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг гүйцэтгэгчид даруй мэдэгдэж, холбогдох нотлох баримт, материал, тооцоололд үндэслэн засвар хийлгэх буюу дутуу хийгдсэн ажлыг дахин гүйцэтгүүлж болно. Их хэмжээний алдаа гарсан нь гүйцэтгэгчийн ажлын чанарын хяналтын үнэлгээг бууруулах үндэслэл болно.

7.8 Аудитын ажлын чанарыг хянахдаа судалгааны асуулгаас гадна бусад мэдээлэл цуглуулах арга техникүүд болон ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, баримтын шалгалт, биет ажиглалт зэрэг арга зүй, горимыг ашиглана.

7.9 Гүйцэтгэсэн аудитын ажлын чанарыг дараах үзүүлэлтээр үнэлнэ.

Аудитын төлөвлөлтийн үе шатны хяналт	30 хувь
Аудитын гүйцэтгэлийн үе шатны хяналт	30 хувь
Аудитын тайлагналын үе шатны хяналт	40 хувь

7.10 Гэрээгээр гүйцэтгэсэн аудитын ажлын чанарт өгсөн үнэлгээнд үндэслэн гүйцэтгэгчтэй гэрээ сунгах эсэх талаарх саналаа Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулна.

Найм. Аудитын ажлын чанарыг баталгаажуулах

8.1 Үндэсний Аудитын Газрын Чанарын баталгаажуулалтын албанаас хараат бус аудитын компаниудын гүйцэтгэсэн ажлын чанарын хяналтыг жил бүр баталгаажуулна.

8.2 Аудитын ажлын чанарын хяналтын баталгаажуулалтыг эрсдэлд суурилсан түүврийн аргаар Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД

АУДИТ ХИЙХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, АУДИТЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ

Ес. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

- 9.1 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани нь санхүүгийн тайландаа аудит хийх гүйцэтгэгчийг холбогдох хуулийн дагуу бие даан сонгон шалгаруулах бол журмын энэхүү бүлгийг мөрдөнө.
- 9.2 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь энэ журмын 2.7.4.3-д заасан үзүүлэлтийг хангаж, Төрийн аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хураангуй жагсаалтад багтсан хараат бус аудитын компаниудаас сонгон шалгаруулна.

Арав. Үнэлгээний хороо байгуулах, ажлын даалгавар боловсруулах

- 10.1 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороонд Үндэсний Аудитын Газар болон аймаг, нийслэл дэх аудитын газраас хоёр хүртэл төлөөллийг оруулна.
- 10.2 Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичигт тусгагдах аудитын ажлын даалгаврыг Төрийн аудитын байгууллагаас гаргасан ажлын даалгаварт үндэслэн бэлтгэнэ. Энэ ажлын даалгаварт нэмэлт байдлаар өөр бусад даалгаврыг тусгаж болно.

Арван нэг. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, төлбөрийн нөхцөл

- 11.1 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид “үйлчлүүлэгч” гэх) нь захиалагч талаас Үндэсний Аудитын Газар эсвэл аймаг, нийслэл дэх аудитын газар болон гүйцэтгэгч “Аудит ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г байгуулж, Монгол Улсын Ерөнхий аудитораар батлуулна.
- 11.2 “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-нд захиалагч, гүйцэтгэгч, үйлчлүүлэгч гурван тал баталгаажуулж гарын үсэг зурах бөгөөд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний загварыг зөвхөн ашиглана.
- 11.3 “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ” нь гэрээ байгуулагдсанаас хойш нэг жилийн хугацаатай байх ба аудитын ажлын чанарын үнэлгээнд үндэслэн сунгагдах эсэхийг шийднэ.
- 11.4 Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын даалгавар нь “Аудитын ажил гүйцэтгэх гэрээ”-ний салшгүй хэсэг болно.
- 11.5 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани нь Төрийн аудитын байгууллагатай зөвшилцсөнөөр аудитын үйлчилгээний нийт төлбөрийг шаардлага хангасан арилжааны банкинд нээсэн дундын данс (эскроу данс)-д байршуулна.
- 11.6 Гүйцэтгэгчийн аудитын үйлчилгээний төлбөрийн 30 хувийг “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ” байгуулж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг

хүлээн авч, аудитын төлөвлөлтийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж хангалттай гэж үзэж баталснаар, 30 хувийг аудитын гүйцэтгэлийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж хангалттай гэж үзэж баталснаар, 30 хувийг аудитын тайланг хүлээн авч, тайлагналын хяналтыг хэрэгжүүлж хангалттай гэж үзэж батлуулсанаар банкны дундын данснаас гүйцэтгэгчид төлнө.

- 11.7 Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани нь ТБОНӨАБАҮХАТ хуульд заасны дагуу аудитын үйлчилгээний төлбөрийн 10 хувийг УИХ-ын чуулганаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын талаар эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд банкны дундын данснаас гүйцэтгэгчид төлнө.

Арван хоёр. Гүйцэтгэгчийн аудитын ажлын чанарыг хянах, баталгаажуулах

- 12.1 Үндэсний Аудитын Газар болон аймаг, нийслэлийн аудитын газрын чанарын хяналтын баг гүйцэтгэгчийн хийсэн аудитын ажлын чанарыг хянана.
- 12.2 Үндэсний Аудитын Газрын Чанарын баталгаажуулалтын албанаас чанарын хяналтын баталгаажуулалтыг жил бүр эрсдэлд суурилсан түүврийн аргаар хийж гүйцэтгэнэ.
- 12.3 Гүйцэтгэгчийн аудитын ажлын чанарыг энэ журмын 3-р бүлэгт дурдсан үе шат, аргачлалыг ашиглан хянан, баталгаажуулна.